

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/16; А/10 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, Цагдаагийн байгууллагын газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.



3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (онцгой байдлын хурандаа П.Баттогтох), Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга (тэргүүн дэд комиссар П.Батбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ  
БАДРАЛ



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР  
Ө.ЭНХТӨР





Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
Цагдаагийн ерөнхий газрын даргын  
хамтарсан 2017 оны 01 дүгээр сарын  
13-ний өдрийн ... дугаар тушаалын  
хавсралт

## ОБЪЕКТЫН БОЛОН ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРИЙН ҮЕД ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ

2017 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын ерөнхий газар /цаашид "ОБЕГ" гэх/, Цагдаагийн ерөнхий газар /цаашид "ЦЕГ" гэх/ дараах нөхцлөөр харилцан тохиролцож, Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон цагдаагийн байгууллага, онцгой байдлын байгууллага, түүний харъяа алба, нэгж хамтран ой, хээрийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гал түймрийн шалтгаан нөхцлийг тогтоох чиглэлээр судалгаа, мэдээлэл, солилцох, алба хаагчдын дунд танхимийн болон дадлагын сургууль зохион байгуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Онцгой байдлын байгууллага, Цагдаагийн байгууллага нь энэхүү журамд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, харилцан үйл ажиллагаандаа хүндэтгэлтэй хандан дэмжлэг, туслалцаа үзүүлэх зарчмыг баримтална.

1.3. Хоёр талын харилцан солилцож буй судалгаа, мэдээлэл нь байгууллагын нууцад хамаарна.

### Хоёр: Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас хэрэгжүүлэх ажил:

2.1. Объектын болон ой, хээрийн гал түймрийн талаарх дуудлага, баримт, мэдээллийг хүлээн авсан тухай бүр төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэн, хэргийн газрын үзлэгт холбогдох мэргэжилтэн, алба хаагчдыг томилж ажиллуулах.

2.2. Объектын болон ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллахаар томилогдсон онцгой байдлын болон цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн, албан хаагч нь хэрэг, зөрчлийн газарт шуурхай хүрэлцэн очиж гал унтраах удирдагчийн удирдлага дор өгсөн үүрэг, чиглэлийн дагуу, хуулийн дагуу гал түймэр унтраах үйл ажиллагаанд оролцоно.

2.3. Объектын болон ой, хээрийн гал түймрийн дуудлагаар хүрэлцэн очсон гал түймрийн улсын хяналтын байцаагч, галын шинжээч нь гал түймэр гарсан шалтгаан, гал түймрийн хэрэг, зөрчилд шаардлагатай мэдээ, мэдээллийг олж авсан, илрүүлсэн бол цагдаагийн байгууллагад шуурхай мэдээлж, хамтран ажиллах.

2.4. Гал түймрийн улсын хяналтын байцаагч, галын шинжээч, албан хаагчид ой, хээрийн гал түймэр гарсан газар орны нөхцөл байдал, онцлог, цаг агаар, түймэрт өртсөн хүн, мал, амьтан, орон байр, автомашин, техник бусад шалтгаан

нөхцлийн талаарх мэдээ, мэдээллийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тавьсан асуултын хүрээнд гаргаж хуулийн хугацаанд хүргүүлэх.

2.5. Гал түймрийн голомтод ажилласан албан хаагч ой, хээрийн гал түймэр гарсан газрын зураглалыг үйлдэж, гал түймэр унтраасан нотломжийн хамт ажлын 5 хоногт багтаан Цагдаагийн байгууллагад хүргүүлэх.

2.6. Гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, гал түймэр гарсан шалтгаан нь тодорхой, эрүүгийн хуульд заасан хохирлын хэмжээнд хүрээгүй ой, хээрийн гал түймрийн хэрэг зөрчлийг гал түймрийн улсын хяналтын байцаагч холбогдох хууль тогтоомжийн дагуу эцэслэн шийдвэрлэх.

2.7. Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газраас ой, хээрийн гал түймрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг ЦЕГ-ын Мөрдөн байцаах газарт улиралд 1 удаа, төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага орон нутагт гарсан ой, хээрийн гал түймрийн тоо, бүртгэл, мэдээллийг сар тутам цагдаагийн байгууллагад хүргүүлж тулгалт хийж, гал түймрийн шалтгаан нөхцөл, эзэн холбогдогч, хохирлын хэмжээг тогтоосон талаарх хэргийн материалын холбогдох хэсэгтэй танилцаж, шаардлагатай баримт, мэдээллийг гаргуулж авах.

2.8. Хаврын хуурайшилтын улирал /03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр/, намрын хуурайшилтын улирал /09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр/-ыг хүртэл ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах, арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэн дүгнэж үр дүнг тооцох.

2.9. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн байгууллага, орон нутгийн Засаг даргын тамгын газар, байгаль орчныг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтантай хамтран байнгын болон хөдөлгөөнт хяналт, шалгалтын цэгийг ажиллуулах.

2.10. Цагдаагийн байгууллагаас объектын болон ой, хээрийн гал түймрийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг, тусалцаа үзүүлэх, ажиллах нөхцөл боломжоор хангах, шаардлагатай баримт, мэдээлэл, лавлагааг үнэ төлбөргүйгээр гаргаж өгөх.

### **Гурав: Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх ажил:**

3.1. Ой, хээрийн гал түймрийн талаарх дуудлага, баримт, мэдээллийг хүлээн авсан тухай бүр төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад мэдэгдэн, хэргийн газрын үзлэгт холбогдох мэргэжилтэн алба хаагчдыг томилж, ажиллуулах.

3.2. Объектын болон ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллахаар томилогдсон цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн, алба хаагчид хэргийн газрын үзлэгийг удирдан галын шинжээч, гал түймрийн улсын хяналтын байцаагч, холбогдох бусад мэргэжилтнийг оролцуулан хамтран ажиллах.

3.3. Цагдаагийн алба хаагч нь гал түймрийн улсын хяналтын байцаагчид "Гал түймэр гарсан тухай акт"-ыг үйлдэхэд шаардлагатай баримт, мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд багтаан гаргаж хүргүүлэх.

3.4. Цагдаагийн байгууллагаас шалгаж, шийдвэрлэсэн ой, хээрийн гал түймрийн хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, учирсан хохирол, эзэн холбогдогчийг тогтоосон, хариуцлага хүлээлгэсэн талаар баримт, мэдээллийг Онцгой байдлын байгууллагаас хүргүүлсэн албан бичгийн дагуу гаргаж өгөх.

3.5. Онцгой байдлын байгууллагаас объектын болон ой, хээрийн гал түймрийн талаарх гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй ирүүлсэн мэдээ, мэдээллийг хүлээн авч шалгаж, шийдвэрлэх, хариу мэдээлэх.

3.6. Төв, орон нутаг, ногоон бүсэд зорчих тээврийн хэрэгсэлд гал унтраагуур байгаа эсэхэд хяналт тавих, ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх

зорилгоор төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагатай хамтран байнгын болон хөдөлгөөнт хяналт, шалгалтын цэгийг ажиллуулах.

3.7. Онцгой байдлын байгууллагаас объектын болон ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөл боломжоор хангах, шаардлагатай баримт, мэдээлэл, лавлагааг үнэ төлбөргүйгээр гаргаж өгөх.

#### **Дөрөв. Сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд**

4.1. Онцгой байдлын байгууллагаас төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын албан хаагчдад объектын болон ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэр унтраах үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, өөрийгөө болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах чиглэлээр хамтарсан танхимын болон дадлага олгох сургалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах.

4.2. Цагдаагийн байгууллагаас гал түймрийн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох чиглэлээр мэдээлэл солилцох, гал түймэр гарсан үед объектын харуул, хамгаалалтыг зохион байгуулах болон бусад чиглэлээр төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагатай хамтарсан танхимын болон дадлага олгох сургалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах.

4.3. Хамтарсан ажиллагааны хүрээнд хоёр талын холбогдох албан тушаалтнуудад гал түймрийн хэрэг зөрчлийг бүртгэх, мөрдөн байцаах, илрүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэдлэг олгох зорилгоор гал түймрийн голомт, гарсан шалтгаан нөхцлийг тогтоох, хэргийн газрын үзлэг шалгалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийж гүйцэтгэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг төв, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.

4.4. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдад объектын болон ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, өөрсдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах арга ажиллагаанд сургаж дадлагажуулах ажлыг төв, орон нутгийн хэмжээнд хамтран зохион байгуулах.

4.5. Хамтран ажиллах журмын хүрээнд зохион байгуулсан сургалт, дадлагын үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх, байгууллагын цахим вэб хуудсанд байршуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах.

4.6. Гал түймрийн хэрэг, зөрчлийн тоо, шалтгаан, нөхцөл байдалд судалгаа, дүгнэлт хийж, гал түймрийн тоо, хохирлыг бууруулах, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр санал, дүгнэлт боловсруулж холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлэх.

#### **Тав. Бусад**

5.1. "Хамтран ажиллах журам"-ыг хоёр талын байгууллагын дарга нар /гарын үсэг зурж/ баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

5.2. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах болон хүчингүй болгох тухай саналыг талууд албан бичгээр гаргана.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР